



Università  
Ca' Foscari  
Venezia

Dear colleagues,

We are pleased to announce that the next European Conference of Mongolian Studies will be held at Ca' Foscari University of Venice, on November 27-28, 2024, on the occasion of Marco Polo's 700<sup>th</sup> anniversary.

The conference will focus on the history, culture, religion, language, and art of the Mongols, as well as Mongolia's historical and current political, economic, and global relations, and explore the prospects for the future. The conference will be a platform for discussion on the role and present state of Mongolian studies and their further development.

We would be honored by your presence at the conference and invite you to deliver a paper on a topic of your choice within your area of research. Presentations can be conducted in either Mongolian or English and should not exceed 20 minutes, followed by a 10-minute discussion session.

The organizers will provide participants with a list of recommended hotels. The conference will take place at Ca' Dolfin Palace, located at Dorsoduro 3825/e – 30123, Ca' Foscari University of Venice, Italy.

Please note that **travel and accommodation expenses** will be the responsibility of the participants.

**Important dates:**

- Title submission: June 30, 2024
- Abstract submission: September 15, 2024
- The European Conference on Mongolian Studies: November 27th and 28th, 2024 (Arrival on November 25th and Departure on November 29th, 2024)

**Conference contacts:**

- [erdeneochir@num.edu.mn](mailto:erdeneochir@num.edu.mn)
- [ragagnin@unive.it](mailto:ragagnin@unive.it)

We look forward to your participation and contribution to this enriching scholarly event.

Warm regards,

Zayabaatar Dalai

Elisabetta Ragagnin

International Association of Mongolian  
Studies

Department of Asian and North African  
Studies, Ca' Foscari University of Venice



Università  
Ca' Foscari  
Venezia

Эрхэм хүндэт эрдэмтэн судлаач Та бүхний амрыг эрэн мэндчилье.

Олон Улсын Монгол Судлалын Холбооноос Бүгд Найрамдах Итали Улсын Венец хот дахь Ка Фоскарын Их Сургуулийн Ази ба Хойд Африк судлалын тэнхимтэй хамтран Европын Монгол Судлалын Олон Улсын Хурлыг Марко Пологийн 700 жилийн ойг тохиолдуулан Итали Улсын Венец хотноо 2024 оны 11 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсныг Та бүхэнд уламжилж буйдаа таатай байна.

Хурлаар монголчуудын түүх, соёл, шашин шүтлэг, хэл, урлаг, улс төр, эдийн засаг, олон улсын харилцааны өнөөгийн байдал хийгээд хэтийн төлвийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх болно. Энэхүү хурал нь Монгол судлалын үүрэг, өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх чухал боломж байх болно.

Таныг энэхүү хуралд хүрэлцэн ирж, өөрийн судалгааны чиглэлээр илтгэл хэлэлцүүлэхийг урьж байна. Та илтгэлээ монгол юм уу, англи хэлээр илтгэх бөгөөд илтгэлийн хугацаа 20 минут, асуулт хариултын хугацаа 10 минут байна.

Хуралд оролцогч нарт тохиромжтой зочид буудлын нэрийн жагсаалт бүхий мэдээллийг хурал зохион байгуулагч талаас өгнө. Хурал Итали улсын Венец хотын Ка Фоскари Их Сургуулийн Дорсодуро 3825/e – 30123-д байрлах Ка Долфины ордонд болно.

**Анхааруулах нь:** Аялал, байрны зардлыг хуралд оролцогч тал өөрөө хариуцна.

- Илтгэлийн сэдвийг 2024 оны 6-р сарын 30-нийг хүртэл хүлээн авна.
- Илтгэлийн товчлолыг 2024 оны 9-р сарын 15-ныг хүртэл хүлээн авна.
- Хурал 2024 оны 11-р сарын 27-28-нд болно. (Венец хотод очих өдөр: 2024 оны 11-р сарын 25, Венец хотоос явах өдөр: 2024 оны 11-р сарын 29)

**Холбоо барих хаяг:**

- [erdeneochir@num.edu.mn](mailto:erdeneochir@num.edu.mn)
- [ragagnin@unive.it](mailto:ragagnin@unive.it)

Хүндэтгэсэн:

Олон улсын монгол судлалын холбооны  
ерөнхий нарийн бичгийн дарга  
Д.Заяабаатар

Венецийн Ка-Фоскари их сургуулийн  
Ази-Хойд Африк судлалын тэнхимийн  
профессор Элизабетта Рагагнин